



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/224

Ховд

Согтууруулах ундаа худалдан борлуулах,
түүгээр үйлчлэхийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 38 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг /улбар шар түвшин/-т шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 06:00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

2. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан 2021 оны 05 дугаар сарын 17-ны 06:00 цагаас хойш архи согтууруулах ундааг худалдан борлуулахыг үе шаттайгаар нээх эсэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийг олон нийтэд мэдээлж, сурталчлан, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нар, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

-Zax A/224 Ch
20 1263